

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/142/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.09.13 № 49
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ТЭШИГ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Д.МӨНХЗУЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.2 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна. Нийт хөрөнгө буюу үндсэн хөрөнгийн дүн өссөн нь 2022 онд Тэшиг сумын Соёлын төвд дутагдалтай байсан тоног төхөөрөмжийг Булган аймгийн Соёл Урлагийн газраас 10 сая төгрөгийн санхүүжилт, 180 мянган төгрөгийн ном, 1.5 сая төгрөгийн санхүүгийн Динамик программыг худалдан авсан нь өмнөх оноос нэмэгдсэн өөрчлөлт гарсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020053

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 6 зорилтын хүрээнд 28 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 90 хувьтай дүгнэгджээ.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,459,300.00	28,697,521.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	11,033,621.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	11,033,621.49
3121	Төгрөг	-	11,033,621.49
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	11,033,621.49
35	БАРАА МАТЕРИАЛ	12,459,300.00	17,663,900.00
354	Хангамжийн материал	12,459,300.00	17,663,900.00
35410	Бичиг хэргийн материал	127,400.00	127,400.00
35420	Аж ахуйн материал	12,331,900.00	17,536,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	191,128,085.77	190,153,043.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	191,128,085.77	190,153,043.57
392	Биет хөрөнгө	186,003,819.07	183,598,776.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,824,123.92	195,824,123.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(23,531,241.48)	(31,428,899.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,140,971.74	56,140,971.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,692,887.83)	(48,006,503.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,327,667.00	31,327,667.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,578,851.28)	(30,272,619.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,514,037.00	10,014,037.00
393	Биет бус хөрөнгө	5,124,266.70	6,554,266.74
39301	Програм хангамж	1,000,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(208,333.30)	(458,333.26)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,332,600.00	4,332,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	203,587,385.77	218,850,565.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	203,587,385.77	218,850,565.06
51	Засгийн газрын хувь оролцоо	203,587,385.77	218,850,565.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	534,742,562.70	534,742,562.70
512	Хуримтлагдсан үр дүн	(331,427,235.38)	(316,164,056.09)
51210	Өмнөх үеийн үр дүн	(331,427,235.38)	(331,427,235.38)
51220	Тайлант үеийн үр дүн	-	15,263,179.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	272,058.45	272,058.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	203,587,385.77	218,850,565.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	82,207,100.00	111,689,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	78,102,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,717,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,717,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,717,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/		10,000,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	66,385,000.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	66,385,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,207,100.00	33,587,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	33,587,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	33,587,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	98,589,117.07	96,425,920.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,589,117.07	96,425,920.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,805,223.07	95,657,888.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,053,610.00	40,135,542.00
210101	Үндсэн цалин	37,222,310.00	34,513,432.00
210102	Нэмэгдэл	5,831,300.00	3,783,866.00
210104	Урамшуулал	-	1,838,244.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,345,853.00	5,002,724.51
210201	Тэтгэврийн даатгал	3,836,403.64	3,401,841.39
210202	Тэтгэмжийн даатгал	424,933.20	400,242.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	340,906.55	320,161.41
210204	Ажилгүйдлийн даатгал	67,619.09	80,075.41
210205	Эрүүл мэндийн даатгал	675,990.52	800,403.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,308,903.00	29,759,900.00
210301	Гэрэл, цахилгаан	968,903.00	1,419,500.00
210302	Түлш, халаалт	28,340,000.00	28,340,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	344,440.00	525,000.00
210401	Бичиг хэрэг	81,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	98,440.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	427,000.00	1,533,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	129,500.00
210604	Урсгал засвар	347,000.00	1,403,500.00
2107	Томилот, зочны зардал	58,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилот	58,000.00	58,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,953,400.00	5,137,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,898,400.00	5,137,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,314,017.07	13,506,442.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	351,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,314,017.07	13,155,042.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	783,894.00	768,032.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	768,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	583,894.00	32.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	583,894.00	32.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16,382,017.07)	15,263,179.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,382,017.07)	15,263,179.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	82,207,100.00	101,689,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	68,102,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,717,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,717,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,717,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	66,385,000.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	66,385,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,207,100.00	33,587,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	33,587,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	33,587,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	81,207,100.00	88,475,478.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,207,100.00	88,475,478.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,423,206.00	87,707,446.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,053,610.00	40,135,542.00
210101	Үндсэн цалин	37,222,310.00	34,513,432.00
210102	Нэмэгдэл	5,831,300.00	3,783,866.00
210104	Урамшуулал	-	1,838,244.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,345,853.00	5,002,724.51
210201	Тэтгэврийн даатгал	3,836,403.64	3,401,841.39
210202	Тэтгэмжийн даатгал	424,933.20	400,242.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	340,906.55	320,161.41
210204	Ажилгүйдлийн даатгал	67,619.09	80,075.41
210205	Эрүүл мэндийн даатгал	675,990.52	800,403.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,308,903.00	29,759,900.00
210301	Гэрэл, цахилгаан	968,903.00	1,419,500.00
210302	Түлш, халаалт	28,340,000.00	28,340,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	323,440.00	525,000.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	98,440.00	100,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	2,501,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	1,097,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	1,403,500.00
2107	Томилолт, зочны зардал	58,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	58,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,953,400.00	6,008,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,898,400.00	6,008,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,717,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,717,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	783,894.00	768,032.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	768,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	583,894.00	32.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	583,894.00	32.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,000,000.00	13,213,621.49
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,000,000.00	2,180,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,000,000.00	2,180,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,000,000.00	2,180,000.00
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	2,180,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,000,000.00)	(2,180,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	11,033,621.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,033,621.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	534,742,562.70	272,058.45	(331,427,235.38)	-	203,587,385.77
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	534,742,562.70	272,058.45	(331,427,235.38)	-	203,587,385.77
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	534,742,562.70	272,058.45	(331,427,235.38)	-	203,587,385.77
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	15,263,179.29	-	15,263,179.29
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	534,742,562.70	272,058.45	(316,164,056.09)	-	218,850,565.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
--	----------	-----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	101652100.00	33587068.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	101652100.00	33587068.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	100884100.00	33587068.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	49679700.00	1976592.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00	37807100.00	1976592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	6210000.00	247076.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	4222800.00	168000.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	496800.00	19790.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	397400.00	15800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	99400.00	3985.04
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	993600.00	39500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	29759900.00	29759900.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	1419500.00	1419500.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	28340400.00	28340400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	1025000.00	200000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	290,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	2,503,500.00	1,403,500.00
210604	Урсгал засвар	-	-	1,403,500.00	1,403,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	33,587,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	33,587,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	33,587,100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		11,033,621.49

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тэшиг сумын Соёлын төвийн нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэшиг сумын Соёлын төв нь “Үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлж, материаллаг бааз, үйл ажиллагааны чадавхыг сайжруулан хүний хөгжилд дэвшил гаргана” гэсэн зорилгын доор Төгс төгөлдрийн төлөө хамтдаа эрхэм зорилт болгон ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Тэшиг сумын Соёлын төв нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын ажилтангүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.2 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	82,207,100	11,033,621.49	71,173,478.51
Авлага	0	0	0
Бараа материал	12,459,300	17,663,900	-5,204,600
Үндсэн хөрөнгө	288,139,399.66	300,319,399.66	-12,180,000
Нийт хөрөнгө	203,587,385.77	218,850,565.06	-15,263,179.29
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	534,742,562.70	534,742,562.70	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	203,587,385.77	218,850,565.06	-15,263,179.29

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Нийт хөрөнгө буюу үндсэн хөрөнгийн дүн өссөн нь 2022 онд Тэшиг сумын Соёлын төвд дутагдалтай байсан тоног төхөөрөмжийг Булган аймгийн Соёл Урлагийн газраас 10 сая төгрөгийн санхүүжилт, 180 мянган төгрөгийн ном, 1.5 сая төгрөгийн санхүүгийн Динамик программыг худалдан авсан нь өмнөх оноос нэмэгдсэн өөрчлөлт гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 75.8 сая, орон нутгийн төсвөөс 33.5 үйл ажиллагааны орлогоос 3.0 сая, нийт зарлагыг 112.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 112.3 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 10.0 сая төгрөгөөр бууруулж, 102.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч үндсэн хөрөнгө бэлтгэх саналыг хасаж баталсан шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 10.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 28 арга хэмжээг санхүүжүүлэхээр 99.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 3.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 65.8 сая, орон нутгийн төсвөөс 33.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 90.6 сая төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа /80101/	62117000	51083378.51	11033621.49	82
2	Уран бүтээл хийлгэх /80214/	3000000	3000000	0	100
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	768000	768000	0	100
4	Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	4300000	2217000	2083000	52
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/	31163400	31163400	0	100
6	Нийтлэг үйлчилгээ /80112/	2423700	2423668	32	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тэшиг сумын Соёлын төв нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагат төсөл хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Соёлын төвд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй	2022 он	0	0	0	0

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй үндсэн үйл ажиллагаанаас 32 төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэшиг сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.5 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 101.7 сая төгрөгөөс 80 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж ажилласан. Байгууллагын батлагдсан төсвийн зохистой зарцуулж ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 оны Шилэн дансны мэдээллийн Шилэн дансны тухай хуулийн дагуу бүрэн мэдээлж ажиллажээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Булган аймаг дахь Төрийн аудитын газраар санхүүгийн тайлангаа баталагаажуулж дансны ангилал буруу бүртгэсэн 1 зөвлөмжийг авсан байна. Энэхүү зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллажээ.

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэшиг сумын Соёлын төвийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1.04 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 0.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

3 ширхэг галын хор 183,000 төгрөгөөр О.Энхбатаас авсан боловч и-баримтаар хөшигний үнэ утгатай ПТМС ХХК-иас шивсэн нэр данс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Соёлын төвийн дуу гаргагч шатаж 1,040,000 төгрөгийн шингэн буюу сэлбэгийн авч сольсон боловч техникийн дүгнэлт, тодорхойлолтгүй.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэшиг сумын Соёлын төв	2	1223.0	1	183.0			1	1,040.0				
Дүн			1	183.0			1	1,040.0				